



## БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/243

Улаанбаатар хот

### Шагнах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан журмын 4 дүгээр зүйлийн 4.2, 4.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.3, 5.10, 5.13 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тулгар төрийн 2226, Их Монгол Улсын 811, Ардын хувьсгалын 96 жилийн ойн баярын өдөр, Улаанбаатар хотын Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын түүхт 70 жилийн ойг тус тус тохиолдуулан дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж, эрхэлсэн ажилдаа амжилт гаргаж, идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа хавсралтад дурдсан нэр бүхий иргэдийг Дүүргийн “Хүндэт тэмдэг”, Засаг даргын нэрэмжит “Өргөмжлөл”-өөр шагнасугай.

2. Дүүргийн “Хүндэт тэмдэг”, Засаг даргын “Өргөмжлөл”-д дагалдах мөнгөн шагналыг холбогдох, шагналд тодорхойлсон байгууллагын зардлаас гаргахыг зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Б.Амартүвшин/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВДАВАА